

## ТАНИЛЦУУЛГА

### 1. Төсөл хэрэгжүүлэх эрх зүйн орчин

**Аж ахуйн нэгжийн эрх:** “Хүдрэнт” ХХК нь 9011054065 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.

**Орд ашиглах тусгай зөвшөөрөл:** “Хүдрэнт” ХХК-д АМГТХЭГ -ын 2013 оны 01-р сарын 30 -ны өдрийн шийдвэрээр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хонгор-3 нэртэй газарт ашигт малтмал ашиглах MV-017256 дугаартай тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон.

**Ордын нөөцийн баталгаажуулалт:** ЭБМЗ-ийн 2012 оны 1-р сарын 11-ний өдрийн ХХ-01-04 тоот дүгнэлт, АМГ-ын даргын 2012 оны 1-р сарын 23-ны өдрийн 46 тоот тушаалаар В+С зэрэглэлээр батлагдсан 192872 т хүдэр, 73396.1 т хайлуур жоншны нөөцийг хүлээн авсан.


### 2. Төсөл хэрэгжүүлэх субъект

**Төсөл хэрэгжүүлэх субъектын байршил:** “Хүдрэнт” ХХК.

**Ордын байршил:** Хонгорын хайлуур жоншны ордын “Хонгор - IV ба VII” ордууд нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн урагш 330 км, Сайншанд хотоос баруун хойш 130 км, Даланжаргалан сумын төвөөс урагш 20 км, төмөр замын Айраг өртөөнөөс баруун тийш 28 км зайд тус тус байрлаж байна (зур.1).

Тус компанийн MV-017256 дугаартай тусгай зөвшөөрлийн 24.93 га талбайн булангийн цэгүүдийн солбицлуудыг доор үзүүлэв (зур.2).



 Хонгорын хайлуур жоншны срд

Зураг № 1. Хонгорын хайлуур жоншны ордын байршил

Тусгай зөвшөөрлийн талбайн солбицол

Хүснэгт № 2

№	Уртраг	Өргөрөг
1	108° 59' 6.67"	45° 47' 46.61"
2	108° 58' 44.67"	45° 47' 46.61"
3	108° 58' 44.67"	45° 48' 3.62"
4	108° 59' 6.67"	45° 48' 3.62"



Зураг № 2. MV-017256 тусгай зөвшөөрлийн талбай

**ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

**Газрын гадаргуу:** Физик газар зүйн хувьд энэ дүүрэг говийн хойд хэсгийн бага хэрчигдсэн дунд зэргийн өндөртэй намхан уулс, налуу дов толгодлог гадаргын хэлбэржил бүхий нутагт багтана. Хойд хэсэгт нь харьцангуй намсан 1220-1250 м өндөртэй намхан уулс зонхилох бөгөөд түүгээр Монголын төмөр зам дамжин өнгөрдөг. Хамгийн өндөр нь Хонгорын хайлуур жоншны ордоос хойт талд орших 1313.1 м өндөртэй Их Хонгор овоо уул бөгөөд зүүн хойшоо, баруун хойшлох тутам

аажмаар намсч Бор хоолой Холбоо, Айрагийн хөндийд 1000-1150 м хүрнэ. Төв болон баруун,

баруун хойт хэсэгт ижил өндөртэй, намхан уулс, жижиг дов толгодын хэлбэр зонхилно.

**Ус зүй:** Энэ хавьд тогтмол урсгалт гол, горхи байхгүй ба харин 200-300, хааяа 3600 л/с ундаргатай олон тооны худагтай, 40 гаруй шорвог нуур бий. Ордоос зүүн урагш орших Бужгарын цагаан, Нартын нуурууд хур тунадас болон хөрсний усаар тэжээгддэг.

**Цаг уур:** Тус район нь хуурай уур амьсгалтай учир жил, хоногийн температурын ялгаа ба агаарын хуурайшилт ихтэй учир унах хур тундасны хэмжээ харьцангуй бага байдаг. Хур тунадасны дийлэнх нь 6-8 саруудад ордог. Жилийн температур 0-5 хэм. Сарын дундаж температур 12, 1, 2-р саруудад -17°C-21.7°C зарим үед -35°C хүрдэг. Жилд унах тунадасны хэмжээ 150-343 мм, голдуу зун, намарт унадаг. Агаарын чийгшил өвөлд 85 % зунд 60-80 %. Анхны хүйтрэлт 9-р сарын эхээр болдог. Салхилалт голдуу хойд болон баруун хойд зүгээс 3-5 м/сек хавар 18-24 м/сек хүрдэг.

**Ан амьтан:** Ан амьтан цөөнтэй, туулай, зурам, оготоно гэх мэт жижиг мэргэчид, хярс, үнэг, чоно зэрэг араатан амьтад нилээд элбэг, монголд өргөн тархалттай хээрийн шувууд, (хэрээ, элээ, бүргэд, шаазгай, болжмор, чогчого, ногтруу өргөн тархалттай байдаг.

**Хүн ам зүй, дэд бүтэц:** Тус ордын орших районд Даланжаргалан, Хар-Айраг сумын төвүүд, төмөр замын 25-р зөрлөг Шивээговь ба Чойр хотхон, “Алтан тал” хоршоо зэрэг төв суурин газар ойр орших бөгөөд эдгээрээс хамгийн том нь Чойр, Шивээ говь хотхон юм. Шивээ говь нь төмөр замын 22-р зөрлөгөөс баруун урагшаа 2 км зайд орших ба Шивээ Овоогийн хүрэн нүүрсний ордыг түшиглүүлэн байгуулсан орчин үеийн төрхтэй хотхон юм.

Тэнд харилцаа холбооны салбар, ахуйн үйлчилгээний төв, 12 жилийн сургууль хүн эмнэлэг засвар механикийн цех, барилга засварын газар, Шивээ Овоогийн нүүрсний уурхайн захиргаа, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллагатай. Улаанбаатар хотын IV цахилгаан станцыг эрчим хүчний нүүрсээр байнга хангаж ажилладаг томоохон нүүрсний уурхай юм.

## **БҮЛЭГ I. ОРДЫН ГЕОЛОГИ**

### **I.1. Геологийн судалгааны түүх**

Дүүргийн судалгааны түүх нь ордын талбай урд хэсэгт 1935-1938 онуудад В.К.Чайковский 1:200000 геологийн зураглалын ажил явуулснаар эхэлсэн гэж үздэг. Тус дүүрэгт нийт янз бүрийн шатны ажлуудыг 1935-1981 он хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн байна.

Хонгор-3 талбайн Хонгор-IY, YII хайлуур жоншны ордуудад 2009-2011 онуудад Хүдрэнт ХХК өөрийн хөрөнгөөр хайгуулын ажил гүйцэтгэж хүдрийн нөөцийг (B+C) зэрэглэлээр тогтоосон.


## **I.2. Ордын геологийн тогтоц**

Ордын хүдрийн биетүүд нь хоёр зэрэгцээ бүсэд оршино. Хойт бүс нь “Хонгор - IV” ордын хүдрийн 1-р биет, өмнөд бүс нь “Хонгор - VII” ордын хүдрийн 1-3-р биетүүдийг агуулна. “Хонгор - IV” ордын хүдрийн 1-р биет 70-72° налуутай баруун хойшоо унаж, 30° чиглэлд сунаж тогтсон байна.

Өмнөд бүсийн “Хонгор - VII” ордын хүдрийн биетүүд нь өргөргийн дагуу сунаж, урагшаа 70° уналтай. Нэлээд томоохон хүдрийн биет нь доломитжсон шохойжингийн метасоматит өөрчлөлтөөр судал үүссэн бөгөөд формац доторх давхраат хэвтэш байдлаар оршино.

“Хонгор - IV” ордын хүдрийн биет-1 нь “Хонгор - VII” ордын хүдрийн 1-р биетийн зүүн хойд салаалсан үргэлжлэл дээр гипсометрийн илүү дээд түвшинд оршино. Энэ нь шохойжингийн өөрчлөлтөөр болон хагарлын дагуу судал маягаар үүссэн гүн биш байрлалтай хүдрийн биет юм. Хүдрийн биет нь гадаргуу дээр 170 м урттай, 0.5-11.4 м, дунджаар 4.75 м зузаантай илэрсэн, бодит зузаан нь 4.48 м. Уг биет нь шохойжингийн горизонтийн зүүн хойд төгсгөлд орших бөгөөд баруун хойш 70-72° уналтай. Хэвтэш нь агуулагч чулуулагтайгаа нийцлэг байрлалтай, хүдрийн бүс нь 250 м урт, 8.0-20.0 м зузаан, босоо шахуу байрлалтай, мэшил маягийн биет юм. Хүдрийн биетийн доод зааг нь зүүн урагшаа 15 м хүртэл гүнд шургасан ба баруун урд зааг нь гадаргууд гарчээ. Хүдэр агуулагч нь филлит, хааяа шохойжин. Филлит нь хүдрийн биетийнхээ дагуу аргиллитжсан, хааяа каолинитжсан шавар үүссэн нь хүдрийн бүсийн хил зааг орчимд ажиглагдана. Энэ биетэд зүүн хойш чиглэлтэй ил малталтаар олборлолт явуулсан бөгөөд түүнд өргөргийн дагуу буюу түүнтэй ойролцоо байрлалтай эгц босоо уналтай, 10 см өргөн хагарлаар бараг шилжилтгүйгээр хэрчигдсэн байдал ажиглагдсан байна. Хүдэр нь нийтдээ ногоон-саарал шавар дотор том хэмхдэс байдлаар оршино.

Хайлуур жоншны хүдэр нь метасоматит гаралтай, нягт, хатуу, жижиг талст хөхөлбөр, хүрэн саарал өнгөтэй торлог, хэлхээслэг текстур ажиглагдана. Хайлуур жонш нь бараан саарал, саарал өнгөтэй, хааяа хөхөлбөр, ногоовтор туяатай буюу өнгөгүй байдаг. Кварцтай хам ургалт үүсгэх бөгөөд кварц нь цайвар-саарал өнгөтэй, шаазан маягийн төрхтэй, хааяа том талстлаг байна. Хайлуур жоншны дундаж агуулга нь 64.44 %. Хүдрийн биетийн зүүн хэсэгт гадаргууд шохойжингийн блокт кварцын судлууд илэрчээ.



## НЭГ. БАЙГАЛЬ ОРЧИНЫ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨЛТ

### 1.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

- Уурхайн эдэлбэр газрын агаарын бохирдолтыг аль болох бага байлгах үүднээс уурхайн авто замуудыг дулааны улиралд тогтмол услах болон тэсэлгээний үед тоосжилт бага байлгах тал дээр анхаарч цэнэгийн түгжээсэнд бутлаж бэлтгэсэн дайрга ашиглах, тэсэлгээний мөргөцгийг тэсэлгээний өмнө усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Уурхайн олборлолтонд өртөх, хөрсний гадаад овоолго уурхайн доторхи зам харилцаа барилга байгууламж зэрэгт өртөх 2.27 га буюу нийт 2.07 га талбайн үржил шимт хөрсийг урьдчилан 0.3-0.5 м-ийн зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах бөгөөд ордын ашиглалтын явцад болон ашиглаж дууссаны дараагаар хийгдэх нөхөн сэргээлтэнд ашиглана.
- Уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр шинэчлэн гаргаж батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж явах бөгөөд түүнд гарах зардлыг нөхөн сэргээлт байгаль хамгаалах зардлын тооцоо хэсэгт тодорхой тусгасан болно.

- Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хийхдээ гацаад овоолгод дарагдах талбайг боломжит хамгийн бага байлгах зорилгод тулгуурласан байгаа.
- Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, маршрутыг тогтоож, тоног төхөөрөмжүүдийг парклах талбайнуудыг тусгайлан байгуулах замаар онц шаардлагагүй олон салаа зам гарч газрын гадарга эвдэгдэхээс сэргийлнэ гэж үзэж байна. Зам, талбайд ашиглагдах нийт талбайг уурхайн ашиглалт дууссаны дараагаар нөхөн сэргээнэ.

## **1.2 Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх талаар явуулах үйл ажиллагаа нь дараахь талбаруудад чиглэгдвэл зохино. Үүнд:**

- Нөхөн сэргээлт хийгдсэн талбайг байгалийн тэнцвэрт байдлыг хадгалсан, унаган төрхөндөө орсон, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байлгах.
- Талбайн хөрсний усыг бохирдуулахгүй байх арга хэмжээ авах.
- Газрын хэвлийд үүссэн хоосон орон зай, ил уурхайн карьер зэрэгт тэмдэг тэмдэглэгээг сайн хийж өгөх,
- Уурхайн дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулах явцад болон төслийн хэрэгжилтэнд ашиглах хүнд машин механизм, тээврийн хэрэгслүүдийг түр болон зөвхөн зааж өгсөн замын маршрутаар явуулах, тоосжилтыг багасгах үүднээс замыг услаж байх.
- Талбайд үүсэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цэвэрлэх.
- Гал түймрээс сэргийлэн сонор сэрэмжтэй ажиллана. Галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгааг ажиллагсадад бүрэн өгч, гал түймрийн үед ажиллах зохион байгуулалт хийж мөрдөх.
- Эвдэрсэн газрыг тарималжуулах ургамлын төрөл зүйл, тариалах арга ажиллагааг тухайн талбайн хөрсний шинж чанар, бүтэц болон газрын гадаргын налуу болон бусад нөхцөл байдалтай уялдуулан сонгох бөгөөд үр суулгац тариалах ажлыг ургамал ургах хамгийн тохиромжтой хугацаанд явуулах.

## **1.3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт**

Энэхүү төлөвлөгөө нь "Хүдрэнт" ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Хонгорын хайлуур жоншыг далд аргаар олборлох төслийн ашиглалтын өмнө болоод ашиглалтын үе шатанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой юм.

Мөн байгаль орчныг хамгаалах чиглэлээр аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг

- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр өөрийн ажилтан ажилчдын дунд сургалт, семинарыг улиралд нэг удаа тогтмол зохион байгуулах,
- Гал түймэр, үер усны аюул зэрэг байгалийн гай гамшгийн үед авагдах арга хэмжээний зөвлөмжийг гаргаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох,
- Байгаль орчин, хүрээлэн байгаа орчноо хайрлан хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг таслан зогсоох үзэл баримтлалыг нийт ажилтан, ажилчдын оюун ухаанд төлөвшүүлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажшгах,
- Жил бүр ажлын төлөвлөгөөндөө байгаль хамгаалах, нөхөн сэргээх сөрөг нөлөөллийг таслан зогсоох зардлыг тусган төлөвлөж ажиллах,

#### **1.4. Байгаль хамгаалах төлөвлөгөөний агуулга**

Төслийн хэрэгжүүлэх үе шат бүрт гарах гол болон сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагавраас урьдчилан сэргийлэх, түүнийг багасгах, нөхөн сэргээх замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх арга зам, зөвлөмж зэргийг багтаасан болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулсан аргачлал

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамруулан авч үзлээ. Энэхүү төлөвлөгөө нь хайлуур жонш олборлох үйл ажиллагаа явуулах хугацаанд хүчин төгөлдөр байна.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчныг хамгаалах хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-уудыг, Байгаль орчны Сайдын тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачилсан заавар”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ” зэргийг удирдлага болгон ажиллалаа.

#### **1.5. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө**

##### **Хөрсний бохирдол, элэгдэл:**

Өнгөн хөрс хуулах, карьер нээх, овоолго хийх, хүдэр олборлох, тээвэрлэх, ангилан ялгах үйл ажиллагаагаар хөрс эвдэрч бохирдохоос гадна шатах, тослох материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч болзошгүй. Бохирдлын эх үүсвэр нь түлш шатахууны агуулах, бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис (угаалгын нунтаг, саван, шампунь) зэрэг болно. Уурхайд ажиллагсад, ойр орчинд байгаа хүн, мал, бичил амьтан, ургамал амьтан зэрэг нь нөлөөлөлд өртөх объект болно. Байгаль орчинд бохирдол үүссэн тохиолдолд бохирдол нь ургамал, хөрсөөр дамжин хүрээгээ тэлэх магадлалтай. Эвдэрсэн газар, хөрсийг стандарт MNS 5917:2008-ын дагуу нөхөн сэргээнэ.

Хөрсийг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материал ил задгай асгахыг хориглоно. (БОЯ, ЭХЯ-ны сайдын 1989.06.22-ны 68/А/61 дугаарын тушаал).

Газар ашиглалтын бүртгэл мэдээг хөтөлж, холбогдох байгууллагад орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт заасан хугацаанд тайлагнана.

##### **Агаар орчны бохирдол:**

Хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас элдэв гаж үнэр гарах, тоосжилт, утаа тортог, CO, SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>-ын хэмжээ ихэсч болзошгүй.

Агаарын бохирдол нь ордод ажиллагсад, ойр орчимд буй хүн, мал, амьтан, ус, ургамал, хөрсөнд нөлөөлж болзошгүй.

Эрүүл ахуйн хяналтын ерөнхий байцаагчийн тушаалаар батлагдсан “Хот суурингийн агаар дахь хорт бодисын агууламжийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг” (Улсын ариун цэврийн байцаагчийн 1989 оны 11 тоот тушаалын 2-р хавсралтаар) баримтална.

##### **Усны бохирдол:**

Далд уурхайн ашиглалтын түвшин нь 1 горизонт буюу 50м-н гүнд ашиглагдах бөгөөд энэ түвшинд гүний ус илрээгүй бөгөөд уурхайн технологийн болон ундны усны хэрэгцээг хангах зорилгоор 140м гүний худаг гаргасан худгийн паспортыг хавсаргав.

Бохирдлын эх үүсвэр нь бохирдсон ус, жорлон, бохирын цэг, шатах, тослох материал, машин тэрэг угаах, ахуйн бохир ус зэрэг болно. Дээрх эх үүсвэрүүд нь гадаргын болон газар доорх усыг шууд ба шууд бусаар бохирдуулах, горимд өөрчлөлт оруулах магадлалтай. Ус бохирдоход ордод ажиллагсад, ойр хавийн хүн, мал, ан амьтан өртөх

эрсдэлтэй. Ундны усны чанарын УСТ900-92 стандарт , гадаргын болон газар доорх усны ариун цэврийн хамгаалалтын бүсийн дүрэм , журмыг баримтална. Гадаргын болон газар доорх усны шинжилгээг орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу хийлгэж байх болно.

### Ургамлын бүрхэвчийн бохирдол

Бохирдолын эх үүсвэр нь автохөсөг болон бусад өөрөө явагч машин механизм дураараа зорчих, шатах тослох материал ил задгай асгаснаас үүсэх бохирдол нь ургамлын бүрхэвчийг бохирдуулах гол шалтгаан тул хамгаалалтын бүсийн дүрэм журам боловсруулж ажиллах шаардлагатай.

### Ан амьтан:

Уурхайн эдэлбэр газрын орчимд амьтны аймгийн хувьд туурайтнаас цагаан зээр, махчин амьтадаас чоно, үнэг, хярс, мануул мэрэгчдээс хулгана, үхэр огодой, бозлог, туулай, алаг даахай, жигүүртнээс тас, бор бүргэд, сар, шонхор, элээ, хэрээ, харцага, тагтаа, ногтруу, болжмор, хэвлээр явагчдаас могой, хонин гүрвэл, мэлхий зэрэг ан амьтад оршино. Эдгээр амьтад нь автотехникийн дураараа зорчих болон хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас болж /хориотой үе болон зөвшөөрөлгүй ан амьтан агнаж устгах/ дайжих, устах аюултай тул ан агнуурын тухай хуулийн заалтуудыг нарийн мөрдөж ажиллах шаардлагатай.

### Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хариуцах эзэн
<b>1. Агаарын чанар</b>			
1.1	Тэсэлгээний үед үүсэх тоосыг байгаль орчинд тархахаас сэргийлж, мөргөцгийг усаар шүршиж тэсэлгээ хийх талбайг урьдчилж чийгшүүлэх, мөн тоосжилтоос хамгаалж овоолго болон замыг усаар шүрших		Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч
1.2	Ажилчдын эрүүл мэндийг үзүүлж мэргэжлээс шалтгаалах өвчний байдлыг тодорхойлох	150.0	
	Нийт зардал /мян.төг/	150.0	
<b>2. Газрын гадарга, газар доорх усан орчин</b>			
2.1	Уурхайн дотор болон уурхайн ойр орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх (урьдчилан сэргийлэх арга хэмжээнд)	Дотоод зардлаар	Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч, хяналтын инженер
2.2	Тоосжилтыг дарах зорилгоор автозам, уурхайн карьерийн мөргөцөг, шинэ овоолгын тоосжилтоос хамгаалах усалгаанд ус ашигласны төлбөр /1,0га 1,5м <sup>3</sup> х 90хон х 1300төг/	500.0	
	Нийт зардал /мян.төг/	500.0	
<b>3. Хөрсөн орчин</b>			
3.1	Хатуу хог хаягдал ахуйн химийн бодисыг эмх цэгцтэй хадгалах	150.0	Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын
3.2	Техникийн засвар үйлчилгээг тусгай талбайд явуулах	100.0	



3.3	Хөрсний шинжилгээг ОХШ хөтөлбөрт заасан хугацаанд хийлгэх	Хяналт шинжилгээний хөтөлбөрт багтсан	байцаагч, хяналтын инженер
	Нийт зардал /мян.төг/	250.0	
<b>4. Ургамлан нөмрөг</b>			
4.1	Уурхайн олборлолтын талбай ургамал талхлагдсан газруудад олон наст ургамлын үр тариалж ургамалжуулах, орчныг тохижуулах	Өөрсдийн зардалаар	Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч, хяналтын инженер
4.2	Орчныг байнга чийглэж, ургамал нөмрөгийг сэргээн сайжруулах зорилгоор усалгааны ажил хийж байх	300.0	
	Нийт зардал /мян.төг/	300.0	
<b>5. Байгаль орчны менежментийн асуудал</b>			
5.1	Болзошгүй аюулын үед орон нутгийн онцгой байдлын газартай хамтран ажиллах	1,200.0	Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч, хяналтын инженер
5.2	Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж сургалт явуулах	300.0	
	Нийт зардал /мян.төг/	1,500.0	
	Бүгд зардал /мян.төг/	2,100.0	

### **Хоёр. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

Ордод урьд өмнө хайгуул явуулсан ил малталтуудын гарш хэсгийн ухаш, уулын ажлын улмаас бий болсон цөмрөлт, хотойлт үүссэн талбайг овоолгын чулуугаар дүүргэж тэгшилнэ. Ашиглалтын хугацаанд БОН үнэлгээний дагуу жил бүрийн менежментийн төлөвлөгөө гаргаж, зардлыг тусган техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж тухай бүр сумын холбогдох газар албадуудад хүлээлгэж өгнө.

### **Нөхөн сэргээх талбайн хэмжээ**

№	Талбайн нэр	Хэмжээ м <sup>3</sup>	Зардал мян.төг
1	Хонгор-3 хайлуур жоншны орд	475	1,500.0

### **Гурав. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Хонгор-3 -ын хайлуур жоншны ордын хайгуулын ажлыг 2013 онд хийж гүйцэтгээд 2014 онд ЭБМЗ-ийн хурлаар оруулж нөөцийг батлуулсан. 2021 онд уг ордыг ашиглах ТЭЗҮ-г боловсруулж Уул Уурхайн Яамны ЭБМЗ-н хурлаар оруулж батлуулсан бөгөөд 2022 онд уг ордыг ашиглах уулын ажлын төлөвлөгөөг батлуулж үйл ажиллагаа эхэлж байгаа тул дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд Даланжаргалан, Айраг өртөө орчмын газар үүссэн хур хогийг цэвэрлэх, түүнээс үүссэн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажил хийхээр төлөвлөгөөг боловсруулав. Энэ ажилд 2,0 сая төгрөг төсөвлөөд байна.

## **Дөрөв. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө**

Хонгор-3 -ын хайлуур жоншны гүний уурхайг 2015 онд нээж ажиллуулж байгаа бөгөөд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж тооцсон болно.

## **Тав. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Уг ордын лицензийн талбайд архелоги болон палентлогийн судалгаа 2017 онд хийгдсэн ба судалгааны тайланг үндэслэн уг зөвлөмжийн дагуу ажиллаж байна.

## **Зургаа. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

### **-Уурхайн тэсэлгээний ажилд хэрэглэх химийн бодис аммонит**

**Одоогоор уг ордыг ашиглахдаа тэсэлгээний ажил хийх шаардлагагүй байгаа бөгөөд цаашид тэсэлгээний ажил зайлшгүй шаардлагатай нөхцөлд энэ төлөвлөгөөг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно.**

Аммонит нь 79% ус даах чадвартай амиакын шүү, 21%-н тортилийн хольц бүхий нэгдэл юм. Аммонит нь хий тоосны аюулгүй далд уурхайнуудад чийгтэй ба нойтон мөргөцгийн хатуу чулуулагт тэсэлгээ хийхэд зориулагдсан. Аммонит нь хүний эрүүл мэндэд дараах байдлаар үйлчилнэ.

1. Амьсгалын замаар
2. Хоол боловсруулах эрхтнээр
3. Арьс салстаар дамжин хордуулах эрсдэлд өртөх боломжтой.

### **Урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

- Тэсэлгээний дараа агааржуулалтын ажиллагааг сайн хийх
- Аммонитийг хадгалж буй орчинд хүнсний зүйл хадгалахгүй байх
- Аммониттай харьцаж байх үед малгай, бээлий, хормогч, амны хаалт хэрэглэж байх
- Тэсэлгээний ажил явуулах үед түүний нэгдсэн дүрмийг нягт баримтлан ажиллах
- Тэсэлгээний аюулгүй бүсийн радиусыг 200м-с доошгүй зайд тогтоож ажиллах явдал нь осол гарахаас урьдчилан сэргийлж, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг багасгах үндсэн нөхцөл болно.

### **Аммонитийн хадгалалт**

Аммонитийг хадгалахдаа дараах 2 үзүүлэлтийг голлон анхаарч аммонит хадгалах агуулахыг барина.

- Шатамхай бодис, металлуудтай хамт хадгалж болохгүй
- Халахаас хамгаалж сэрүүн хуурай газар хадгална.

### **Зөвшөөрөгдөх концентраций**

- Аммонитийг хүн ам оршин сууж байгаа орчны агаарт зөвшөөрөгдөх хэмжээ 0.30мг/л
- Аммиакийн ажлын байрны зөвшөөрөгдөх дээд хэмжээ 20мг/л
- Усны эх булаг, усан санд байх хэмжээ 0.2мг/л

### **Аммонитийн учруулж болзошгүй аюул, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээ**

- Аюулын бүсийг 500м-с доошгүй зайд тогтооно.
- Зөвхөн хамгаалах хэрэгсэлтэй хүн гүйцэтгэнэ.
- Гал гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
- Шатах тослох материал болон бусад шатамхай материалаас зайлуулна
- Гал гарсан үед галыг ус хөөсөөр унтраана.
- Бодис асгарсан газарт элс асгаж тусгаарлана.

-Тэсрэх бодис тээвэрлэх ачиж буулгах үед аюулгүй ажиллагааны дүрмийг нягт баримтлан ажиллана. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад 1,5 сая төгрөг төсөвлөсөн.

### Долоо. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны явцад үүсэх ахуйн болон техникийн хог хаягдлыг ангилан ялгаж дараах байдлаар арга хэмжээ авна.

1. Уурхайн тосгонд үүсэх ахуйн хог хаягдал болох үнс нурам нүүрсний хог цаасан хог хаягдал хуванцар сав шилэн сав зэргийг тус тусад нь ангилан ялгаж дараах зоиулалтаар устгал хийнэ.

- Үнс нурмыг тусгайлсан нүх бэлдэж булж устгана.

- Цаас болон хуванцар шил савыг багцлан бэлдэж уурхайгаас 25 км-н зайд орших сумын төвийн хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлнэ.

2. Техникийн хог хаягдал Үүнд: Резинэн дугуй төмөр эдлэлийн хаягдал, шатах тослох материалын хаягдлууд багтана.

- Шатах тослох материалын хаягдлыг тусгай саванд хуримтлуулж дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлнэ.

- Төмрийн хаягдал резинэн дугуй зэргийг аймгийн төвийн хоёрдогч түүхий эдийн цэгүүдэд нийлүүлэх арга хэмжээнүүдийг авч ажиллана.

### Хог хаягдлыг бууруулах болон устгах арга хэмжээ

№	Хийгдэх ажлууд	Нийт зардал мян.төг	Хариуцах эзэн
1	Хатуу хог хаягдлыг цуглуулах болон боловсруулах арга хэмжээ авах	50.0	Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч, хяналтын инженер
2	Шингэн хог хаягдлыг цуглуулах болон боловсруулах арга хэмжээ авах	50.0	
3	Түр жорлон, муу усны нүх байгуулах	Байгаа	
4	Хатуу хог хаягдлын цэг байгуулах	Байгаа	
5	Хатуу болон шингэн хог хаягдлын цэг орчимд ариутгал болон халдваргүйжүүлэх ажлыг хийж байх	100.0	
	Дүн	200.0	

### Найм. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

- Байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээхэд Хонгор-3 -ын ордыг ашиглах төслийн нарийвчилсан үнэлгээ, төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээх төсөл, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ажиллана.
- Уурхайн хүчин чадал бага тул удирдлагын нүсэр бүтэц байх шаардлагагүй юм. Иймд байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг уурхайн дарга хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.
- Нөхөн сэргээлт болон байгаль орчныг хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгнө.

- Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль журмын дагуу уурхайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргэж тайлагнаж байна.

**Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал Мян.төг	Хариуцагч
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, энэ чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоох	Жил бүр	200.0	Захирал
2	Байгаль орчны асуудлыг хариуцан зохион байгуулах үүргийг удирдлагын хүрээний ажилтандаа хариуцуулан ажиллуулах	Олборлолтын хугацаанд	500.0	Захирал
3	Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллах, үйлчлүүлэх талаар тохиролцох, ажил үйлчилгээний онцлогтой холбогдон гарч болох өвчлөл, гэмтэл хордлогын тухай мэдээлэл харилцан солилцож зохих бэлтгэлийг хангах арга хэмжээ авах	Жил бүр	500.0	Захирал
4	Байгаль орчинд үзүүлж болзошгүй болон гол нөлөөллийн талаар нарийвчилсан үнэлгээнд дурьдсан зөвлөмжүүдийг дэс дараатай хэрэгжүүлэн үр дүнг БОЯ, орон нутгийн зохих албадад танилцуулан зөвлөгөө авч байх	Жил бүр	200.0	Захирал
Дүн			1,400.0	

### Ес. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

#### Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээний ажил	Холбогдох стандартууд	Шинжилгээ хийх лаборатори	Хийх ажил
Агаар	<p>А. Төслийн талбай орчмын агаарын чанар  Хянах зүйлс: Тоосний нийт агууламж мкг/м<sup>3</sup>, Нүүрстөрөгчийн давхар исэл СО<sub>2</sub> мкг/м<sup>3</sup>, Азотын давхар исэл NО<sub>2</sub> мкг/м<sup>3</sup>, Хүхэрлэг хийн агууламж  Хяналтын лавтагдал: Жилд 2 удаа  Шинжилгээний байршил: Уурхайн эргэн тойронд</p>	<p>MNS5246-2003.4.X Агаар дахь радоны хэмжээг тодорхойлох арга,  MNS4991-2000.10.x Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын бүсийн агаар дахь хорт бодисын концентрацыг хэмжих аргачлалд тавих шаардлага, MNS5365-2004.4.X Агаарын чанарын ерөнхий асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга,  MNS5885-2008.8.X Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэххэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага, MNS3384-1982.3.X Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага. MNS4048-1988.2.X Байгаль хамгаалал. Агаар мандал.  Тоосны хэмжээг жингийн аргаар тодорхойлох,  MNS(ISC)4227-2002.23.x Хүрээлэн буй орчны агаарын чанар хяналтын төлөвлөгөө,  MNS5631-2006.4.X Цацрагийн хамгаалалт. Цөмийн цацрагийн тунгийн зөвшөөрөгдөх хэмжээ</p>	<p>Байгаль орчны төв лаборатори, Цөмийн физикийн лаборатори</p>	<p>- Дээжлэлт,  - Лабораторийн шинжилгээ</p>
	<p>Б. Агаар дахь сонсох долгионы өөрчлөлт буюу дуу чимээ  Хянах зүйл: Чимээ шуугианы түвшин</p>			<p>чимээ шуугианы түвшинг тогтоох</p>

	Хяналтын давтагдал: жилд 2 удаа Шинжилгээний байршил: Уурхайн эргэн тойронд			
Хөрс	<p>Хөрсний үржил шимийн өөрчлөлт Хянах зүйл: - Хөрсний бохирдлыг тогтоох,          Үржил шимийн зузаан, /см/          Саармагжуулах чадвар,          Ялзмагийн хэмжээ, / мг/кг /          Карбонатын хэмжээ, / мг/ кг /          Фосфорын хэмжээ, / мг/ кг /          Хяналтын давтагдал: Жилд 1 удаа          Хяналтын цэгүүд: Уурхайн орчмын зам, талбай орчимд,          Тэсэлгээний агуулахын ойролцоо,          Засварын газрын ойролцоо,          Авто зогсоол,          Шатах тослох материалын агуулах орчимд          Хөрсний чанарын баталгаа, газар ашиглалт          Хянах зүйл: Хөрсний чанарын баталгаа гаргуулж, зураглал хийлгэх          Хяналтын давтагдал: 5 жилд 1 удаа.          Эрх бүхий байгууллага мэргэжлийн</p>	<p>MNS5850 -2008.6.х Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS3298-1991.5.Х БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ. ХӨРС.          Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд.          MNS(ISO)10390-2001,7.х Хөрсний чанар. рН тодорхойлох,          MNS(ISO)I 1046-2003.19.х Хөрсний чанар - Эрдэс тосны агуулгыг тодорхойлох - Нил улаан туяаны спектрометр ба хийн хроматографын арга,          MNS5546-2005.4. х Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага,          MNS(ISO)I 1269.2.2002.9.х Хөрсний чанар. Хөрсний ургамалд бохирдуулагчийн нөлөөлөллийг тогтоох. 2-р хэсэг: Дээд ургамлын өсөлт болон гарцанд химийн бодисын нөлөөлөл,          MNS4915-2000.2.х Байгаль орчин. Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага,          MNS17.5.1.19-1992.9.х Байгаль орчны хамгалаал. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага.</p>	<p>Байгаль орчны төв лаборатори, ХААИС-ын Хөрсний химийн лаборатори</p>	<p>Дээжлэлт, Лабораторийн шинжилгээ Г азрын төлөв байдлыг шинжлэн судалж, хөрсний чанарыг үнэлэх</p>
Гадаргын ба газрын доорхи ус	А. Гадаргын ба гүний усны чанар	MNS(ISO)5667.1.2002.22.х Усны чанар. Дээж авах. 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар		

	<p>Хянах зүйл: Гидрохими. хүнд металл. хатуулаг /рН/, Cl, SO<sub>4</sub><sup>2-</sup>, NO<sub>2</sub>, NO-T, CO<sub>3</sub>, HCO<sub>3</sub><sup>-</sup>"</p> <p>Хяналтын давтагдал: Жилд 3 удаа Хяналтын цэгүүд: нийт 8 цэгт Гидрогеологийн хяналтын цэгт /4цэгт/</p>	<p>MNS(ISO)5667.2.2001.14.х Усны дээж. Дээж авах. 2-р хэсэг. Дээж авах аргачлалын заавар MNS4586 -1998.3.Х Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага</p>		
	<p>Б. Гадаргын ба гүний усны нөөц</p> <p>Хянах зүйл: Усны нөөц. түвшний өөрчлөлт</p> <p>Хяналтын давтагдал: Жилд 2 удаа Хяналтын цэгүүд: нийт 8 цэгт Унд ахуйн зориулалтаар ашиглаж буй худаг орчимд /4цэгт/ Гидрогеологийн хяналтын цэгт 14</p>	<p>MNS6148-2010.5.Х Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS3342 -1982.2.Х Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага</p>		
	<p>В. Технологийн хаягдлын аж ахуйн ба түүний ашиглалт</p> <p>Хянах зүйл: Хаягдал ус, аюулгүй ажиллагаа, хаягдлыг цэвэрлэх, хоргүйжүүлэх ажиллагаа, хаягдал усыг буцаан ашиглах талаар</p> <p>Хяналтын давтагдал: Жилд 1 удаа Хяналтын цэгүүд: Гүүр. хоолойн</p>	<p>MNS(ISO)5667.11.2000.13.х Усны чанар-Дээж авах:11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж MNS3936 -1986.25.х Ахуйн хэрэгцээ. Ундны зориулалттай ус. Хээрийн шинжилгээний аргууд</p>		
<p>Ажлын байрны эрүүл ахуй</p>	<p>А. Ажлын байрны нөхцөл</p> <p>Хянах зүйл: Ажлын байрны эрүүл ахуй, Гэрэлтүүлэг, Хөдөлмөр хамгаалах, аюулгүй ажиллагааны иж бүрэн хэрэгсэл, Галын аюулгүй байдлын арга хэмжээ,</p>	<p>Хөдөлмөрийн эрүүл ахуйн нэгдсэн дүрэм</p>	<p>Ажлын болон харуулын байранд</p>	<p>Ажлын байрны эрүүл аюулгүй орчинд ажиллах байдлыг хангах</p>

	Иргэний хамгаалалтын арга хэмжээний төлөвлөлт Хяналтын давтагдал: Жилд 2 удаа			
	Ажилтан ажиллагсдын эрүүл мэндийн байдал		Бүх ажиллагсад	Эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт хамруулах



№	Ажлын нэр	Жилд хийлгэх шинжилгээний тариф	Нэг жилийн нийт шинжилгээний зардал /мян.төг/
1	Агаарын сорьц шинжилгээ хийлгэх	1 цэг х 1 удаа	300.0
2	Усны шинжилгээ хийлгэх	1 цэгт х 2 удаа	500.0
3	Хөрсний шинжилгээ хийлгэх	2 цэгт х 1 удаа	500.0
4	Ургамлын бүрхэвчээс дээж авах	1 цэг х 1 удаа	300.0
	Нийт дүн		1,600.0

**Арав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь**

Тайлангийн жилийн эцэст байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийг сумын иргэдийн хуралд тухайн оны 12-р сард танилцуулж хамтран хэлэлцэж зохих дүгнэлт шийдвэрүүдийг гаргаж ажиллана. Хурлын зардалд 500.0 мян.төг төсөвлөв.

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулга**

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам стандарт
1	Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө	Уурхайн эдэлбэр	мян.төг			500.0	"Хүдрэнт" ХХК	Даланжаргалан сум БО-ны улсын байцаагч	Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 2780 мян.төг-г тухайн ажлуудад зарцуулсан байна.	MNS5246-2003.4.X Агаар дахь радоны хэмжээг тодорхойлох арга, MNS4991-2000.10.x Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын бүсийн агаар дахь хорт бодисын концентрацыг хэмжих аргачлалд тавих шаардлага, MNS5365-2004.4.X Агаарын чанарын ерөнхий асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга,
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Хүдрийн биет	м <sup>3</sup>	465	3600	1,500.0	"Хүдрэнт" ХХК	Даланжаргалан сум БО-ны улсын байцаагч	Хайгуулын ажлын үед малтсан 6 суваг, 5 траншейд техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.	MNS5885-2008.8.X Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэххэм хэмжээ.
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Компаний удирдлага				-	"Хүдрэнт" ХХК	Даланжаргалан сум БО-ны улсын байцаагч	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний талаар бүрэн судалгаа хийсэн байна.	Техникийн ерөнхий шаардлага,
4	Нүүлгэн шилжүүлэх,	Компаний				-	"Хүдрэнт" ХХК	Даланжаргалан сум БО-	Уурхай шинээр нээгдэж байгаа	

	нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	удирдлага						ны улсын байцаагч	тул нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө хийгдээгүй	MNS3384-1982.3.X Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага.
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Компаний удирдлага	мян.төг			-	"Хүдрэнт" ХХК	Даланжаргалан сум БО-ны улсын байцаагч	Түүх соёлын өвийг хамгаалах талаар палентлоги болон архелогийн хүрээлэнтэй гэрээ хийсэн байна.	MNS4048-1988.2.X Байгаль хамгаалал. Агаар мандал. Тоосны хэмжээг жингийн аргаар тодорхойлох, MNS(ISC))4227-2002.23.x Хүрээлэн буй орчны агаарын чанар хяналтын төлөвлөгөө, MNS5631-2006.4.X Цацрагийн хамгаалалт. Цөмийн цацрагийн тунгийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS5850 -2008.6.x Хөрсний чанар.
6	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Уурхайн эдэлбэр				-	"Хүдрэнт" ХХК	Даланжаргалан сум БО-ны улсын байцаагч	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг ХХАА-ны дүрэмийг чанд баримтлан ажиллана.	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS3298-1991.5.X
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Уурхайн эдэлбэр	мян.төг			1,000.0	"Хүдрэнт" ХХК	Даланжаргалан сум БО-ны улсын байцаагч	Хог хаягдлыг төлөвлөгөөнд тусгасны дагуу хэрэгжүүлнэ.	БАЙГАЛЬ
8	Байгаль орчны	Компаний	мян.төг			1,400.0	"Хүдрэнт" ХХК	Даланжаргалан сум БО-	БОМТөлөвлөгөө хэрэгжүүлэхэд	

	менежмент ийн төлөвлөгөө хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт ын төлөвлөгөө	удирдлага						ны улсын байцаагч	компаний удирдлагын зүгээс байнга хяналт тавьж ажиллана.	ХАМГААЛАЛ. ХӨРС. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. MNS(ISO)10390- 2001,7.х Хөрсний чанар. рН тодорхойлох, MNS(ISO)I 1046- 2003.19.х Хөрсний чанар Эрдэс тосны агуулгыг тодорхойлох - Нил улаан туяаны спектрометр ба хийн хроматографын арга, MNS5546-2005.4. х Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага, MNS(ISO)I 1269.2.2002.9.х Хөрсний чанар. Хөрсний ургамалд бохирдуулагчийн нөлөөлөллийг тогтоох.
9	Байгаль орчны хяналт шинжилгээ ний хөтөлбөр	Уурхай н эдэлбэр	мян.тө г			-	"Хүдрэнт" ХХК	Даланжарга лан сум БО- ны улсын байцаагч	БОХШинжилгээ ний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хөрсний дээжийг 2 цэгээс : Х690269,4 - Y5170118,0 Х690512,0 - Y5169898,5 усны дээжийг: Х690062,4 - Y5169877,8 ургамлын дээжийг: Х690067,0 - Y5170009,2 агаарын дээжийг: Х690318,6 - Y5170052,5 цэгүүдээс тус тус авна.	

10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	Компаний удирдлага	мян.төг			500.0	"Хүдрэнт" ХХК	Даланжаргалан сум БО-ны улсын байцаагч	БОМТөлөвлөгөөний биелэлтийг 12-р сард сумын иргэдийн хуралд оруулж танилцуулна.	2-р хэсэг: Дээд ургамлын өсөлт болон гарцанд химийн бодисын нөлөөлөл, MNS4915-2000.2.х Байгаль орчин. Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага, MNS17.5.1.19-1992.9.х Байгаль орчны хамгалаал. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага. MNS(ISO)5667.1.2002.22.х Усны чанар. Дээж авах. 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар MNS(ISO)5667.2.2001.14.х Усны дээж. Дээж авах. 2-р хэсэг. Дээж авах аргачлалын заавар MNS4586 -1998.3.Х Усан орчны чанарын үзүүлэлт.

										<p>Ерөнхий шаардлага MNS6148-2010.5.X Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS3342 -1982.2.X Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага MNS(ISO)5667.11.200 0.13.x</p>
	Дүн					4,700. 0				

**УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хянасан огноо	Шинжээч бөглөнө
Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар	Шинжээч бөглөнө
Дүгнэлт	Шинжээч бөглөнө
<ul style="list-style-type: none"> <li>• Шийдвэрийн төсөл</li> <li>• Ололт, амжилттай тал</li> <li>• Дутагдалтай сул тал</li> <li>• Шаардлага</li> </ul>	

**НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД,  
ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “*хамааралгүй*” гэж бөглөнө.
- 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	"Хүдрэнт" " ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011054065
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Аялал жуучлал, Гадаад худалдаа
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, 6-р хороолол, Метромалл Центр, 610 тоот
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Б.Мөнхбат, 99111764 <a href="mailto:bataa_chuluun@yahoo.com">bataa_chuluun@yahoo.com</a>
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Б.Батбаяр, 99442024 <a href="mailto:Bat_geo@yahoo.com">Bat_geo@yahoo.com</a>

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../  
огноо /.... он .... сар .. өдөр /

1.2	1. Төслийн нэр	Хонгор-3 нэртэй хайлуур жоншны ордыг 2017 онд ашиглах Б.О.Менежментийн төлөвлөгөө
	1. Төслийн харъяаллын байршил	Дорноговь аймаг Даланжаргалан сум
	3. Төслийн ангилал а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт б. ил уурхай, далд уурхай, шороон орд в. баяжуулах үйлдвэр	Жонш ил уурхай
	4. Төсөл эхэлсэн огноо	2015
	5. Төсөл хэрэгжих хугацаа	5 жил
	6. Уурхайн хаалт эхлэх огноо	2025 он
	7. Хаалтын дараах зориулалт	Бэлчээрийн
	8. ТЭЗҮ баталсан огноо	2021 он
	9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	-
	10. Ажилчдын тоо	48
	11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	134310 тн хүдэр
	12. Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц - замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл; - шатахуун түгээгүүрийн тоо - шатахуун агуулахын агууламжийн хэмжээ - тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт	Уурхай – Даланжаргалан - 20км - - Одоогоор агуулах бариагүй ТМ-н склад - 5тн багтаамжтай байх

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг  
огноо

/...../  
/.... он .... сар .. өдөр /



**ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/  Дугаар  Хүчинтэй хугацаа  Талбай	Металл бус АМ / Хайлуур жонш/  MV - 017256  2043.01.29  24.93 га
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар  Хүчинтэй хугацаа	-  -  -
	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	-
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	-
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2017 БОНХЯамны шинжээч .....
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2017 БОНХЯам Байгаль орчны ерөнхий шинжээч .....
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2017-11-03
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	2022 он

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../  
огноо /..... он .... сар .. өдөр /

9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах	1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 маягт хавсаргав.
10. ТХГН-ын тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах	Тодорхойлолтыг хавсаргав.
11. Тухайн жилд баримтлах стандартын дугаар <ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний</li> <li>• Олон улсын</li> </ul>	MNS 5246 - 2003. 4.х MNS 4941 - 2010. 10.х MNS 5365 - 2004. 4.х MNS 5885 - 2008. 8.х MNS 3298 - 1991. 5.х MNS (ISO)1 - 1046. 2003. 19.х MNS 17.5.1.19 - 1992. 9.х MNS 6148 - 2010. 5.х MNS 3936 - 1986. 25.х

#### **ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрын А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2 дугаар хавсралтанд тусгагдсанг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах
- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/
- Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “хангалттай” гэсэн дүгнэлтийг оруулна.
  - урьдчилан сэргийлэх арга хэмжээ
  - эрсдлийн үед авах арга хэмжээ
  - учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ
  - хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тухайн жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинен материал /дугуй, сав баглаа боодол/ зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг  
огноо

/...../  
/.... он .... сар .. өдөр /

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	-
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
3.2	1. Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Агуулах байхгүй
3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ <ul style="list-style-type: none"> <li>• Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/</li> <li>• Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/</li> <li>• Аюултай хог хаягдал</li> </ul>	Хатуу хог - 10тн Хатуу төмөр - Резин дугуй г.м - 5тн Ажилласан масло, гидро шингэн - 400л
	2.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	1,000,000.0 төгрөг

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг  
огноо

/...../  
/..... он .... сар .. өдөр /

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

- Доорх хүснэгтийн 4.12 - 4.1.7 -д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 —д тусгагдана.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	5,400,000.0₮
	2. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	1,000,000.0₮
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	500,000.0₮
	4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	1,500,000.0₮
	5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	-
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	500'000₮
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	1,400,000.0 ₮
4.2	1. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	0 ₮
4.3	1. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	500,000.0₮

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг  
огноо

/...../  
/.... он .... сар .. өдөр /

### ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.
- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1	<p style="text-align: center;">Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тосгон</li> <li>• Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт)</li> <li>• Хог хаягдлын цэгийн байршил</li> <li>• Хог хаягдлын агуулахын байршил               <ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын далан</li> </ul> </li> <li>• Химийн бодисын агуулахын байршил</li> <li>• Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил               <ul style="list-style-type: none"> <li>• Тухайн жилд хуулах хөрс</li> <li>• Гадаад, дотоод овоолго</li> </ul> </li> <li>• Техникийн нөхөн сэргээлтийн талбай</li> <li>• Биологийн нөхөн сэргээлтийн талбай               <ul style="list-style-type: none"> <li>• Гүний худгийн байршил</li> </ul> </li> <li>• Дүйцүүлэн хамгааллын байршил</li> </ul>	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../  
 огноо /..... он .... сар .. өдөр /

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГ АХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД  
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь багананд “тодорхойлсон”, “тодорхойлоогүй” “хамааралгүй” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнийн нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

<b>Нөлөөллийн ангилал</b>	<b>А. Тооцсон эсэх</b>	<b>Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх</b>	<b>В. Нөлөөллийн гэрчмийг тодорхойлсон эсэх</b>	<b>Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх</b>	<b>Дүгнэлт</b>
6.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	Тодорхойлсон Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлоогүй Тодорхойлоогүй Тодорхойлоогүй	Тодорхойлсон Тодорхойлсон Тодорхойлсон	Уурхайг ашиглаж байгаа
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Уурхайг ашиглаж байгаа
6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах - амьдрах орчинг хомсдуулах - нөөцийг бууруулах	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	Уурхайг ашиглаж байгаа
6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Уурхайг ашиглаж байгаа

6.5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс					
- Хамгаалах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Уурхайг ашиглаж байгаа
- Нүүлгэн шилжүүлэх	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../  
огноо /.... он .... сар .. өдөр /

### ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “тийм”, “үгүй” хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтэнүүд “хангалттай” “хангалтгүй” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон	Г. Дүгнэлт
7.1. Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	1	Тийм	Тийм	Уурхайн үйл ажиллагаа үргэлжилж
7.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	5	Тийм	Тийм	Уурхайн үйл ажиллагаа үргэлжилж
7.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ - техникийн/ га - эзэлхүүн - биологийн /га	1.0	Тийм	Тийм	Уурхайн үйл ажиллагаа үргэлжилж байгаа
7.4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	-	-	-	Уурхайн үйл ажиллагаа үргэлжилж байгаа
7.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин	1	Тийм	Тийм	Уурхайн үйл ажиллагаа үргэлжилж байгаа

7.6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	-	Үгүй	Үгүй	
7.7. Байгаль орчны менежментиний удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	1	Тийм	Тийм	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../  
огноо /.... он .... сар .. өдөр /

### **НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

<b>Хяналт шинжилгээний дээж</b>	<b>А. Дээж авах цэгийн тоо</b>	<b>Б. Дээж авах цэгийн байршил</b>	<b>В. Давтамж</b>	<b>Г. Төсөв</b>
Хөрс	2	Жонш ялгах хэсэг	1 удаа	500'000₮
Ус	1	Гүний худаг	2 удаа	500'000₮
Амьтан	1	Уурхайн орчим	1 удаа	150'000₮
Ургамал	1	Уурхайн дэвсгэр нутаг	1 удаа	150'000₮
Агаар	1	Уурхайн ам Жонш ялгах цех	1 удаа	300'000₮



